



**“БАНК САНХҮҮ 2022”
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ ПРАКТИКИЙН
БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ**



ҮНДЭСЛЭЛ

Аливаа улс орны банкны салбар нь мөнгөний эргэлтийг гардан гүйцэтгэж буй гэдэг утгаараа улсын эдийн засгийн тулгуур багана болж байдаг. Эдийн засгийн хил хязгаар улам тэлэхийн хэрээр хамгийн түрүүнд банк санхүүгийн орчинд олон улсын дагаж мөрдөх стандартуудын хэрэглээ улам өсч, улам бүр нээлттэй болсоор байгааг бид боломж хэмээн харах ёстой ч үүнд бэлэн байх нь хамгаас чухал.

Иймд Монгол Улсад банк, санхүүгийн систем үүсч хөгжсөний 98 жилийн ойд зориулж Их дээд, мэргэжлийн сургуулиудын эрдэмтэн багш нар, судлаачид, оюутан залуучуудын дунд банк, санхүүгийн салбарын өнөөгийн байдлыг судлан, цаашдын хөгжлийн чиг хандлагыг төсөөлөх зорилгоор **“БАНК САНХҮҮ-2022”** эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурлыг зохион байгуулна.

ЗОРИЛГО

Онол, практикийн бага хурлын зорилго нь их дээд сургуулиудын эрдэмтэн багш, судлаачид, оюутан залуучууд, банкны салбарын төлөөллийг оролцуулан үндсэн илтгэлүүдийн хүрээнд хэлэлцүүлэг хийх, банк санхүүгийн чиглэлээр судалгаа хийж байгаа оюутнуудын бүтээлийг дэмжихэд оршино.

Хурлын үйл ажиллагааны хүрээнд дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
Үүнд:

- ❖ Банкны салбарын түүхэн хөгжил, замналын талаар үнэлэлт дүгнэлт өгөх;
- ❖ Банк, санхүүгийн салбарын хөгжлийн өнөөгийн төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;
- ❖ Банк, санхүүгийн салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох;
- ❖ Банкны салбарын хөгжлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлох, эдийн засаг, санхүү банкны хууль эрх зүй, финтек, санхүүгийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлт, ногоон сэргэлтийн талаар судалгаа, шинжилгээ хийх

ХАМРАХ ХҮРЭЭ

Онол, практикийн бага хурлыг ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль, Монголбанкны Дархан-Уул аймаг дахь хэлтэс хамтран зохион байгуулах бөгөөд дэмжигч байгууллагаар Дархан-Уул аймаг дахь Голомт банкны салбар оролцоно.

Мөн Дархан-Уул аймгийн ЗДТГ, Монголын Бизнесийн Зөвлөл, ШУТИС-ийн Бизнесийн Ахисан түвшний сургууль, Санхүү Эдийн Засгийн их сургууль, Дархан-Уул аймаг дахь Агро Экологи Бизнесийн сургууль, “Дархан” дээд сургууль, “Мандах” их сургууль, ХУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль болон Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудын төлөөлөл оролцоно.

ГУРАВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1 Бүтээлийн агуулгын хувьд:

- Онол, арга зүйн үндэслэлтэй;
- Шинэлэг, оновчтой санал, санаачлага дэвшүүлсэн;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
- Бодит байдалд хэрэгжиж болохуйц;
- Эконометрик, статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан;
- **Оюутны ангилалд оролцох судалгааны ажлууд заавал удирдагч багштай байх;**
- Бусдын ажлыг шууд хуулбарлаагүй;
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан;
- Судалгааны шалгарсан болон шинэлэг арга хэрэгслүүдийг ашигласан байх;
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, дүгнэлт, зөвлөмжид хүрсэн байх;

3.2 Оролцогчдын хувьд:

- Оролцогч нь оюутны болон судлаачийн аль ангилалд оролцохоо тодорхой бичих;
- Дотоодын болон гадаадын их дээд сургуулийн 2 ба түүнээс дээш курсийн оюутан байх;
- Судлаачийн ангилалд оролцогч нь эрхэлж буй ажил албан тушаал, мэргэжлээ тодорхой дурдах;
- Багаар оролцож болох ба гишүүдийн тоо 3,-аас ихгүй байна;
- Бүтээлээ заавал 3 хувь хэвлэмэл байдлаар ирүүлэх.

3.3 Бичгийн стандарт:

- Үсгийн фонт – Times New Roman /”Mon” өргөтгөлтэй фонт байж болохгүй/
- Фонтын хэмжээ -12;
- Мөр хоорондын зай-1,5;
- Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;

Үсгийн фонд – Times New Roman

- Үсгийн өндөр 12 pt
- Мөр хоорондын зай 1,5 Single байна.
- Хуудас:дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун

захаас 15 мм

- Цаасны хэмжээ : А4
- Бүтээлийн хуудасны тоо : 30 нүүрнээс ихгүй
- Судалгааны хураангуйг бичсэн байх
- Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичих
- Үг, үсгийн болон утга найруулгын алдаагүй байх
- Илтгэл нь гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт ном зүй гэсэн үндсэн хэсгүүдийг багтаасан байх
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах)

ДӨРӨВ. УРАЛДААНЫ ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Зохион байгуулах комисс бүтээлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг дүгнэх
- Илтгэлийн хугацаа : 10 минут
- Санаагаа ойлгомжтой, цэгцтэй хүргэх
- Асуултанд оновчтой хариулах
- Монголбанк болон хөндлөнгийн төлөөлөгч нараас бүрдсэн багаар шүүлгэж

дүнг гаргах, шалгарсан бүтээлийг Монголбанкны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

ТАВ. ШАГНАЛЫН САН

Оюутны шагнал:

- 1 -р байр өргөмжлөл 100,000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл 80,000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл 60,000 төгрөг

Судлаачийн шагнал:

- 1-р байр өргөмжлөл 200,000 төгрөг
- 2-р байр өргөмжлөл 150,000 төгрөг
- 3-р байр өргөмжлөл 100,000 төгрөг

ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА

Зохиогч өөрийн хаяг, утасны дугаараа бичиж /erdenechuluun@stda.edu.mn/
(Д.Эрдэнэчулуун) хаягаар 2022 оны 4-р сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

**Хугацаа: 2022 оны 4 сарын 28-нд 13 цагаас ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь
Технологийн сургууль дээр зохион байгуулагдана.**

Харилцах утас: Эрдэм шинжилгээний бага хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг
- ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн багш

Л.Отгончимэг- 99026891, Д.Эрдэнэчулуун -99079208,

- Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтсийн ахлах нягтлан бодогч

Д.Жаргалсүрэн- 99084270 нараас тодруулна уу.